

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ.



Ж.НАРАНПУРЭВ

Огноо: 2020.06.19

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт

гэрээний нэр: **УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ**

Гэрээний дугаар: **УДШ/202012005**

Улаанбаатар хот.
2020 он

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын журам: Харьцуулалтын арга

Тендерийн дугаар: **УДШ/202012005**

Улсын Дээд шүүх нь эрх бүхий тендерт оролцогчдоос: **УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ**-ын үйлчилгээ гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх үйлчилгээний техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 07 дугаар сарын 06-ны 10:30 цагаас өмнө цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 11:00 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: 15170. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж, Улсын Дээд шүүхийн байр 402 тоот
Харилцах утас: 51-263138

ХОЁР: ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 1.2 Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: **Амь нас, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллагын зөвшөөрөл**
- Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м() бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:
- 1. Дуудлагын оператортай байх**
2. Шуурхай албаны машин 24 цагаар ажилладаг байх
2. **Тендерийн иж бүрдэл**
- 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
- (а) Үнийн санал;
 - (б) Үйл ажиллагааны хуваарь;
 - (в) Сүүлийн 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ижил төстэй (амь нас, эрүүл мэнд, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал болон эдгээртэй дүйцэхүйц) үйлчилгээг гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэсэн болон одоо хийж байгаа тухайг захиалагч болох түүнтэй холбоо барьж болох нэр, хаяг, төрөл хэмжээ, мөнгөн дүн зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг жил тус бүрээр гаргаж ирүүлэх; /гэрээний хуулбарын хамт, гэрээ дүгнэсэн акт 3-аас доошгүй/
 - (г) Сүүлийн 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн даатгалын үйлчилгээний нийт мөнгөн дүнг жил бүрээр гаргаж ирүүлэх; /2018, 2019 он/
 - (д) Хохирол төлсөн байдал харуулах; /2018, 2019 он/
 - (е) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ; /хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байх/
 - (ё) Даатгалын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, хавсралтын хамт; /хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байх/
 - (з) Өмнөх захиалагчдаас мэдээлэл авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг;

(ж) Тухайн тендерт оролцогчийн санхүүгийн байдлыг харуулах аудитаар баталгаажсан сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, тодруулга, аудиторын дүгнэлтийн хамт; /2018, 2019 он/

(л) Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, харилцагч банк болон холбогдох бусад төрийн байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай албан бичиг; Уг тендерийн баримт бичигт тусгагдсан гэрээ, үйлчилгээний тодорхойлолт болон нөхцөл шаардлагыг бүхэлд нь зөвшөөрч буй тухай бичиг;

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 105 дугаар тогтоол “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журам”-ын 3.12, 3.13-д заасан төлбөрийн чадварын зохистой харьцаа нь **100-с доошгүйг** (2019 оны 4 улирлын байдлаар) харуулсан тодорхойлолт;

- Санхүүгийн зохицуулах хорооны төлбөрийн чадварыг хангасан тухай тодорхойлолт; /2019 оны 2 болон 4 дүгээр улирал, 2020 оны эхний улирлын байдлаар/
- Нөөцийн сангийн хэмжээ 2019 оны жилийн эцсийн байдлаар харуулсан тодорхойлолт;
- Санхүүгийн зохицуулах хорооноос сүүлийн 2 жилийн нөхөн төлбөрийн талаарх тодорхойлолт ирүүлэх;
- Шүүхийн төрөлжсөн архиваас хариуцагчаар хэрэг, маргаанд оролцож байсан эсэх тухай лавлагаа; /Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн дагуу төлөх аливаа төлбөр, хохирлыг барагдуулаагүй байх нь оролцогчийг чадварын шаардлага хангаагүй гэж үзэх үндэслэл болно./
- Тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн аль нэгэн жилийн турш гүйцэтгэсэн амь нас, эрүүл мэнд, гэнэтийн осол, хөдөлмөрийн чадвараа алдсаны, эмчилгээний зардлын даатгал болон эдгээртэй дүйцэхүйц даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн нь хамгийн багадаа 100,000,000 /нэг зуун сая / төгрөгнөөс багагүй байх;
- Тендерт оролцогч нь сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн гэрээтэй ангилал, бүтээгдэхүүн нарийн төвөгтэй байдлаараа дүйцэхүйц ижил 2-оос доошгүй үйлчилгээ үзүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх;

- 3. Тендерийн үнэ**
- 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.
- 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 5. Алдааг залруулах**
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

6. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
7. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ: ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А.ЕРӨНХИЙ ЗААЛТ

- | | |
|---|--|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд |

хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

16. Эцсийн тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Гэрээг цуцлах

17.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын санаачлагаар гэрээ цуцлагдаж болно.

17.2. Талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргавал нөгөө талдаа 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

17.3. Гэрээг цуцлах санал хүлээн авсан тал нь хариуг хүндэтгэх шалтгаангүйгээр ирүүлээгүй бол гэрээ цуцлах саналд заасан өдрөөс эхлэн гэрээг цуцласанд тооцно.

17.4. Даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл гэрээний үлдсэн хугацаанд ногдох даатгалын хураамжаас даатгуулагчийн авсан нөхөн төлбөр, тухайн даатгалтай холдбогдон гарсан зардлыг хасч үлдэх хэсгийг Даатгуулагчид эргүүлэн олгоно.

17.5. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер

гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.6. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**18. Гэрээг
цуцалсан
үед хийх
төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлэ
эс
чөлөөлөх**

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

- 3.1** Төслийн менежер нь *[томилогдсон этгээдийн нэр, хаяг]*
- 4.1** Ажил эхлэх өдөр: 2020
- Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр :.....
- 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш *[тоо]* хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 9.1** Чанарын баталгаат хугацаа 1 жил байна.
- 13.1** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн *[хувь]* байна.⁴
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн *[хувь]* байна.
- 17.1** Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг *[огноо]*-ны дотор гаргаж өгнө.
- Гүйцэтгэлийн зургийг *[огноо]*-ны дотор гаргаж өгнө.
- Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ *[мөнгөн дүн]* байна.
- 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын *[хувь]*-иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БУЮУ ДААТГАЛЫН ЭРСДЭЛҮҮД

Үндсэн эрсдэл:

- 1 Ажил үүргээ гүйцэтгэж байх үеийн болон ээлжийн амралттай байх үеийн эрсдэл;
2. Байгалийн эрсдэл:
Хүчит салхи, цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үер усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт, аянга, гал түймэр, дэлбэрэлт, ус шаварт унах, намагт шигдэх, хорт ургамалд хордох;
3. Ахуйн эрсдэл:
Элдэв зүйлд цохигдох, хавчигдах, хавчуулах, хальтрах, унах, түлэгдэх, хөлдөх, осгох;
Наранд цохиулах, угаартах, хоол, хорт хий, эмийн зүйл, ургамалд хордох, амьтан шавьжинд өртөх;
Зүсэгдэх, дайралтад өртөх;
4. Мал, амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл:
Морь малнаас унах, чирэгдэх, малд дайруулах, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах, мал маллагаа, араатан амьтан, нохойд уруулах, бариулах, мөргүүлэх;
5. Зам тээврийн эрсдэл:
Бүхий л төрлийн тээврийн хэрэгсэл жолоодох, эсвэл зам тээврийн аюул осолд өртөх;
6. Техниктэй харьцах үеийн эрсдэл:
Автомашин, мотоцикл, унадаг дугуй зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл жолоодох болон зорчих, мөн төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, шүргэлцэх, шарвах, унах, живэх зэрэг осол;
7. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1-24.2.3 дахь хэсгүүдэд заасан гэнэтийн ослоос үүдэлтэй эрсдэлүүд;
8. Даатгуулагч гадаад улс оронд албан томилолтоор ажиллах үеийн бүх төрлийн осол, гэмтэл, өвчлөл;
- 9 Бүх төрлийн гэнэтийн осол;

Нэмэлт эрсдэл:

10. Гуравдагч этгээдээс учруулах эрсдэл;
11. Орон сууц худалдан авахад хэрэгжигдэх амь насны даатгал;
12. Бусдад зодуулах, цохиулах, хорлогдох, алуулах;
13. Буу, хутга, мэс зэрэг зэвсэгтэй дайралтад өртөх;
14. Бусад ажил үүргээ гүйцэтгэж байх эрсдэл;
15. Гэнэтийн өвчлөл Үүнд:
 - Албан үүргээ гүйцэтгэх явцад цус харвах;
 - Мухар олгойн хурц түгжрэл;
 - Гэдэсний хурц түгжрэл;
16. Хоол боловсруулах эрхтний цооролт, түлэгдэлт;
17. Өмнө нь оношлогдож байгаагүй эмгэгээс болсон тархины цус харвалт;
18. Ухаан алдалт; (зүрхний цусан хангамж алдагдах болон цус багадалтаас үүдэлтэй)

19. Зүрх хаагдах, зүрхний цочмог шигдээс;
20. Хавдар болон түүнээс үүсэх өвчлөл;
21. Гэнэтийн ухаан алдалтаас үүдэн гарсан эрсдэл;
22. Татаж унах;
23. Хордолт;
24. Бүх төрлийн хордлого;
25. Бусад гэнэтийн эрсдэл;

БАТЛАВ:

ДААТГУУЛАГЧ:

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ДААТГАГЧ:

“..... ДААТГАЛ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.НАРАНПҮРЭВ

.....

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН “АМЬ НАС,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Гэрээний дугаар: УДШ/202012005

Даатгагч:

Даатгуулагч:

Даатгалын гэрээний огноо:

“..... даатгал” ХХК

Улсын Дээд шүүх

2020 оныдүгээр сарын өдөр

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Даатгагчийн нэр, хаяг:
Даатгуулагчийн нэр:
Даатгуулагчийн хаяг:

.....
УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Дээд шүүхийн байр
Утас: Мэдээлэл лавлагаа: 51-261698
Бичиг хэрэг: 51-261544
Факс: Тамгын газар: 11-320622
Майл хаяг: info@supremecourt.mn

Даатгуулагчийн
үйл ажиллагаа:

Монгол Улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч

Даатгалын гэрээний дугаар:

Даатгалын гэрээний
хугацаа:

Нэг жил буюу 12 сар

Даатгалын төрөл:

“Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч,
шүүгчдийн амь нас, эрүүл мэнд”

- Даатгалын эрсдэл:

Үндсэн эрсдэл:

- 1 Ажил үүргээ гүйцэтгэж байх үеийн болон ээлжийн амралттай байх үеийн эрсдэл;
2. Байгалийн эрсдэл:
Хүчит салхи, цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үер усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт, аянга, гал түймэр, дэлбэрэлт, ус шаварт унах, намагт шигдэх, хорт ургамалд хордох;
3. Ахуйн эрсдэл:
Элдэв зүйлд цохигдох, хавчигдах, хавчуулах, хальтрах, унах, түлэгдэх, хөлдөх, осгох;
Наранд цохиулах, угаартах, хоол, хорт хий, эмийн зүйл, ургамалд хордох, амьтан шавьжинд өртөх;
Зүсэгдэх, дайралтад өртөх;
4. Мал, амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл:
Морь малнаас унах, чирэгдэх, малд дайруулах, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах, мал маллагаа, араатан амьтан, нохойд уруулах, бариулах, мөргүүлэх;
- 5 Зам тээврийн эрсдэл:
Бүхий л төрлийн тээврийн хэрэгсэл жолоодох, эсвэл зам тээврийн аюул осолд өртөх;
6. Техниктэй харьцах үеийн эрсдэл:
Автомашин, мотоцикл, унадаг дугуй зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл жолоодох болон зорчих, мөн төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн

хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, шүргэлцэх, шарвах, унах, живэх зэрэг осол;

7. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 үгээр зүйлийн 24.2.1-

24.2.4 дахь хэсгүүдэд заасан гэнэтийн ослоос үүдэлтэй эрсдэлүүд;

8. Даатгуулагч гадаад улс оронд албан томилолтоор ажиллах үеийн бүх төрлийн осол, гэмтэл, өвчлөл;

9. Бүх төрлийн гэнэтийн осол;

Нэмэлт эрсдэл:

10. Гуравдагч этгээдээс учруулах эрсдэл:

11. Орон сууц худалдан авахад хэрэгжигдэх амь насны даатгал:

12. Бусдад зодуулах, цохиулах, хорлогдох, алуулах;

13. Буу, хутга, мэс зэрэг зэвсэгтэй дайралтад өртөх;

14. Бусад ажил үүргээ гүйцэтгэж байх эрсдэл;

15. Гэнэтийн өвчлөл Үүнд:

- Албан үүргээ гүйцэтгэх явцад цус харвах;

- Мухар олгойн хурц түгжрэл;

- Гэдэсний хурц түгжрэл;

16. Хоол боловсруулах эрхтний цооролт, түлэгдэлт

17. Өмнө нь оношлогдож байгаагүй эмгэгээс болсон тархины цус харвалт;

18. Ухаан алдалт; (зүрхний цусан хангамж алдагдах болон цус багадалтаас үүдэлтэй)

19. Зүрх хаагдах, зүрхний цочмог шигдээс;

20. Хавдар болон түүнээс үүсэх өвчлөл;

21. Гэнэтийн ухаан алдалтаас үүдэн гарсан эрсдэл:

22. Татаж унах;

23. Хордолт;

24. Бүх төрлийн хордлого;

25. Бусад гэнэтийн эрсдэл;

Даатгалын нийт үнэлгээ:

.....

Даатгуулагчийн хүлээх хариуцлага:

Өөрийн хүлээх хариуцлага байхгүй.

Нэг шүүгчийн даатгалын үнэлгээ:

Даатгалын нийт хураамж:

Даатгалын гэрээ үйлчлэх нутаг дэвсгэр:

Монгол Улс /Гадаад улсад албан томилолтоор ажиллах үеийн эрсдэл хамруулан ойлгоно./

Даатгалын хураамж төлөх хугацаа:

Даатгалын гэрээ батлагдсанаас хойш ажлын 10 хоногт

Даатгалын хураамжийн хувь:

%

Хураамжийн хөнгөлөлт:

%

ДААТГАЛЫН ГЭРЭЭ

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нэг. Нэр томъёоны тодорхойлолт

1.1.Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:

- 1.1.1. **“Даатгагч”** гэж Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монгол Улсын хуулийн этгээд болохийг;
- 1.1.2. **“Даатгуулагч”** гэж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдийг;
- 1.1.3. **“Даатгалын эрсдэл”** гэдэгт даатгуулагчид хохирол учруулж болох гэрээгээр тохирсон эрсдэл, нөхцөл, үйлдэл, орчин, үйл явдлыг;
- 1.1.4. **“Даатгалын тохиолдол”** гэдэгт даатгуулагчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;
- 1.1.5. **“Даатгалын хураамж”** гэж даатгуулагчийн амь нас, эрүүл мэндийг даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
- 1.1.6. **“Даатгалын нөхөн төлбөр”** гэж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан болон энэ гэрээний дагуу даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;
- 1.1.7. **“Даатгалын үнэлгээ”** гэж даатгуулагч даатгуулсан хэмжээний мөнгөн илэрхийллийг;
- 1.1.8. **“Даатгуулагчийн албан үүрэг”** гэж тогтоосон ажлын байранд болон томилот, ажлын хэсэгт орж шүүн таслах болон бусад ажил эрхлэхийг;
- 1.1.9. Ерөнхий мэдээлэл (schedule) нь даатгалын гэрээний салшгүй хэсэг бөгөөд даатгалын гэрээтэй холбоотой мэдээллийг хураангуйлан харуулсан байна.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1.Энэхүү гэрээгээр даатгуулагчийн амь нас, эрүүл мэндийг даатгуулан хураамж төлөх, даатгагч хууль, энэ гэрээнд заасны дагуу даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг гэрээнд заасны дагуу нөхөн төлөх харилцааг зохицуулна.

2.2.Хоёр тал энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Гурав. Даатгалын зүйл

3.1. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдийн амь нас, эрүүл мэнд нь даатгалын зүйл байна.

Дөрөв. Даатгалын эрсдэл

- 4.1 Ажил үүргээ гүйцэтгэж байх үеийн болон ээлжийн амралттай байх үеийн эрсдэл;
- 4.2. Байгалийн эрсдэл:
Хүчит салхи, цасан ба шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үер Усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт, аянга, гал түймэр, дэлбэрэлт, ус шаварт унах, намагт шигдэх, хорт ургамалд хордох;
- 4.3. Ахуйн эрсдэл:
Элдэв зүйлд цохигдох, хавчигдах, хавчуулах, хальтрах, унах, түлэгдэх, хөлдөх, осгох;
Наранд цохиулах, угаартах, хоол, хорт хий, эмийн зүйл, ургамалд хордох, амьтан шавьжинд өртөх;
Зүсэгдэх, дайралтад өртөх;
- 4.4. Мал, амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл:
Морь малнаас унах, чирэгдэх, малд дайруулах, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах, мал маллагаа, араатан амьтан, нохойд уруулах, бариулах, мөргүүлэх;
- 4.5 Зам тээврийн эрсдэл:
Бүхий л төрлийн тээврийн хэрэгсэл жолоодох, эсвэл зам тээврийн аюул осолд өртөх;
- 4.6. Техниктэй харьцах үеийн эрсдэл:
Автомашин, мотоцикл, унадаг дугуй зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл жолоодох болон зорчих, мөн төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, шүргэлцэх, шарвах, унах, живэх зэрэг осол;
- 4.7. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1- 24.2.5 дахь хэсгүүдэд заасан гэнэтийн ослоос үүдэлтэй эрсдэлүүд;
- 4.8. Даатгуулагч гадаад улс оронд албан томилолтоор ажиллах үеийн бүх төрлийн осол, гэмтэл, өвчлөл;
- 4.9. Бүх төрлийн гэнэтийн осол;

Нэмэлт эрсдэл:

- 4.10. Гуравдагч этгээдээс учруулах эрсдэл;
- 4.11. Орон сууц худалдан авахад хэрэгжигдэх амь насны даатгал;
- 4.12. Бусдад зодуулах, цохиулах, хорлогдох, алуулах;
- 4.13. Буу, хутга, мэс зэрэг зэвсэгтэй дайралтад өртөх;
- 4.15. Бусад ажил үүргээ гүйцэтгэж байх эрсдэл;
- 4.16. Гэнэтийн өвчлөл Үүнд:
 - Албан үүргээ гүйцэтгэх явцад цус харвах;
 - Мухар олгойн хурц түгжрэл;
 - Гэдэсний хурц түгжрэл;
- 4.17. Хоол боловсруулах эрхтний цооролт, түлэгдэлт;
- 4.18. Өмнө нь оношлогдож байгаагүй эмгэгээс болсон тархины цус харвалт;
- 4.19. Ухаан алдалт; (зүрхний цусан хангамж алдагдах болон цус багадалтаас үүдэлтэй)
- 4.20. Зүрх хаагдах, зүрхний цочмог шигдээс;

- 4.21. Хавдар болон түүнээс үүсэх өвчлөл;
- 4.22. Гэнэтийн ухаан алдалт;
- 4.23. Татаж унах;
- 4.24. Хордолт;
- 4.25. Бүх төрлийн хордлого;
- 4.26. Бусад гэнэтийн эрсдэл;

4.27. Зардлын даатгал: Даатгагч нь даатгалын тохиолдлын дараа бий болсон баримтаар нотлогдсон 10.000.000 /арван сая/ төгрөг хүртэлх ослын газраас тээвэрлэх болон яаралтай эмчилгээ үйлчилгээний нэмэлт зардлыг даатгуулагчид хүсэлт гаргасан өдрөөс хойш 3 хоногийн дотор төлнө.

4.28. Эрүүл мэндийн урьдчилсан иж бүрэн шинжилгээ үзлэгийн зардал: Нэг хүнд 200.000 /хоёр зуун мянга/ төгрөг

4.29. Шүдний эмчилгээ нэг хүнд 100,000 /нэг зуун мянга/ төгрөг,

4.30. Өвчтэй байх үеийн эмчлүүлсэн эмчилгээний зардал эмчийн дүгнэлтээр, 20.000.000 /хорин сая/ төгрөг

Тав. Даатгалын үнэлгээ, хураамж

5.1. Даатгалын талууд харилцан тохирч тогтоох бөгөөд ажилтан тус бүрээр үнэлгээг тогтооно.

5.2. Энэхүү гэрээгээр даатгалын нийт үнэлгээ, хураамжийн хувь, хураамж дараах хэмжээтэй байна.

5.2.1. Нэг шүүгчийн сүүлийн 15 жилийн цалингийн хязгаар;
265.000.000 - 500.000.000 төгрөг

5.2.2. Нэг шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн хязгаар;
202.600.000 төгрөг

5.2.3. Нэг шүүгчийн сүүлийн нэг жилийн цалингийн хязгаар;
68.600.000 төгрөг

5.2.4. Нэг шүүгчийн сүүлийн 1 сарын цалингийн хязгаар;
5.500.000 төгрөг

5.2.5. Нийт шүүгчдийн тоо; 25 /одоогоор 19 шүүгч ажиллаж байгаа болно./

5.2.6. Нийт шүүгчдийн даатгалын үнэлгээ;
9.000.000.000 - 10.000.000.000 төгрөг

5.2.7. Даатгалын жилийн хураамж хувь;

5.2.8. Жилийн хураамж;төгрөг

5.2.9. Хураамжийн хөнгөлөлт;%

5.2.10. Төлөх даатгалын хураамж;₮

5.3. Даатгуулагч гэрээнд заагдсан хураамжийг гэрээ байгуулж ёсчилсноос хойш ажлын 10 хоногийн дотор шилжүүлнэ.

5.4. Гэрээнд талуудын эрх бүхийн этгээд гарын үсэг зурж, тогтоосон хугацаанд даатгалын хураамж бүрэн төлөгдсөнөөр гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

5.5. Даатгуулагч тус бүрийн овог нэр, регистрийн дугаар, мэргэжил, эрхэлдэг ажил, албан тушаал, даатгалын үнэлгээ, хураамж зэрэг холбогдох мэдээллийг гэрээнд хавсаргана.

5.6. Энэхүү гэрээний хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Зургаа. Даатгалын гэрээний хугацаа

6.1. Энэхүү гэрээ нь “Ерөнхий Мэдээлэл (Schedule)”-д заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

- 6.2. Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 6.2.1. Хууль болон даатгалын гэрээгээр тогтоосон хугацаа дууссан;
 - 6.2.2. Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
 - 6.2.3. Даатгагч үүргээ гүйцэтгээгүйн улмаас даатгуулагчийн санаачилгаар гэрээг цуцлах;
 - 6.2.4. Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
 - 6.2.5. Гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгохоор талууд тохиролцсон;

Долоо. Даатгагчийн эрх

- 7.1. Даатгуулагчийн өгсөн мэдээ, материалын үнэн зөв эсэхийг шалгах, шаардлагатай бол эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандах;
- 7.2. Даатгалын тохиолдол болсон нөхцөлд газар дээр нь шалгаж танилцах, шаардлагатай гэж үзвэл хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагын туслалцаа авах;
- 7.3. Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, түүнд өөрчлөлт оруулах санал тавих;
- 7.4 Даатгуулагчийн ажиллах орчин, ажлын нөхцөлтэй газар дээр нь очиж танилцах;

Найм. Даатгагчийн үүрэг

- 8.1. Даатгалын тохиолдол бий болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;
- 8.2. Даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөл, баталгааг даатгуулагчид танилцуулах;
- 8.3. Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ;
- 8.4. Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;
- 8.5. Даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж оруулан даатгуулагчид төлөх;
- 8.6. Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

Ес. Даатгуулагчийн эрх

- 9.1. Даатгалын тохиолдол болсон үед хууль болон гэрээний нөхцлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
- 9.2. Даатгалын нөхцөл, үнэлгээ, хураамжийн хувь хэмжээ, нөхөн төлбөр олгох журмын талаар даатгагчаас нэмэлт тодруулга шаардах;
- 9.3. Даатгагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
- 9.4. Даатгалын нөхцөл, үнэлгээ, хураамжийн хувь хэмжээний талаарх мэдээлэл, нэмэлт тодруулга шаардах;
- 9.5. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгагчийн санхүүгийн чадавхийн талаар холбогдох мэдээ, мэдээлэл шаардах;
- 9.6. Даатгагчийн санхүүгийн чадвар муудсан гэж үзэх хангалттай үндэслэл бий болсон тохиолдолд гэрээг цуцлах саналыг даатгагчид тавих;
- 9.7. Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор даатгагчтай бүх талаар идэвхитэй хамтран ажиллах;

9.8. Даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Даатгагчаас шаардах;

Арав. Даатгуулагчийн үүрэг

10.1. Даатгалын хураамжийг “Ерөнхий Мэдээлэл (Schedule)”-д дурьдсан хугацаанд багтаан даатгагчид төлнө.

10.2. Даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэ зөв өгөх;

10.3. Даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээ авах;

10.4. Даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчийн шуурхай албаны утсаар холбогдож даатгалын тохиолдол болсноос хойш 72 цагийн дотор урьдчилан мэдэгдэх (утас, факс, албан бичиг гэх мэт аль боломжтой арга хэлбэрээр);

10.5. Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон нөхцөл байдал болон даатгалын тохиолдол бий болох таагүй нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

Арван нэг. Даатгалын нөхөн төлбөр

11.1. Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар болон энэхүү даатгалын гэрээгээр зохицуулагдана.

11.2. Даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэхэд бүрдүүлэх бичиг баримт:

11.2.1. Өргөдөл, Даатгалын гэрээ;

11.2.2. Эмнэлгийн хуудас: (Хөдөлмөрийн чадвараа түр алдалтын үед) эмнэлгийн магадлагаа, амбулаторийн карт;

11.2.3. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

11.2.4. Эмнэлгийн хуудас олгогдохгүй даатгуулагчийн хувьд эмнэлгийн магадлагаа, амбулаторийн карт, рентген зураг;

11.2.5. Үйлдвэрлэлийн ослын акт (үйлдвэрлэлийн ослын үед);

11.2.6. Шаардлагатай бол замын цагдаа, гал түймэр, шүүх прокурор, мөрдөн байцаах болон шүүх эмнэлгийн байгууллагаас авсан баримт, нотолгоо;

11.2.7. Шаардагдах бусад баримт бичиг; Үүнд:

- Эмнэлгийн хуудас нь “Эмнэлгийн хуудас олгох журам”-д нийцсэн байна.

- Амбулаторийн карт нь уг гэмтэл бэртлийн эмчилгээний бичилттэй байна.

11.3. Даатгуулагчид нөхөн төлбөрийг дараах байдлаар олгоно.

11.3.1. Даатгагдагч хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд:

Даатгагдагч ослын улмаас түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдвал эмнэлэгт хэвтсэн, амбулатори, гэрээр эмчлүүлсэн хугацаанаас хамааруулан тухайн шүүгчийн сүүлийн нэг жилийн цалингийн хэмжээнээс дараах хувиар тооцно.

Нөхөн төлбөрийн хэмжээ	
Даатгуулагч нас барах	Тухайн шүүгчийн нийгмийн даатгалын дэвтрээр баталгаажсан сүүлийн 15 жилийн цалингийн хэмжээгээр олгоно.

Даатгуулагч ажил үүргээ гүйцэтгэж чадахааргүй болсон тохиолдолд	Тухайн шүүгчийн сүүлийн 3 жилийн цалингийн хэмжээнээс тооцно.
Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдах:	Тухайн шүүгчийн сүүлийн нэг жилийн цалингийн хэмжээнээс дараах хувь хэмжээгээр тооцно.
Хөдөлмөрийн чадваргүй байсан хугацаа	Тооцох хувь
1-15 хоног	0,7%/1 өдрийн/
16-30 хоног	15%
31-45 хоног	20%
46-60 хоног	25%
61-75 хоног	30%
76-90 хоног	40%
6 сар хүртэлх хугацаагаар тогтоосон	60%
1жил хүртэлх хугацаагаар тогтоосон	80%
Хөдөлмөрийн чадваргүй байсан хугацааг ажлын өдрөөр тооцно.	

11.3.2 Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хэсэгчилэн алдсан тохиолдолд дараах хэмжээгээр нөхөн олговор олгоно.

11.3.2.1. Хөдөлмөрийн чадвараа 50 хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалингийн үнэлгээний 50 хувиар;

11.3.2.2. Хөдөлмөрийн чадвараа 60 хүртэл хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалингийн үнэлгээний 60 хувиар;

11.3.2.3. Хөдөлмөрийн чадвараа 70 хүртэл хувиар алдсан нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалингийн үнэлгээний 70 хувиар;

11.3.2.4. Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсад тохиолдолд тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалингийн үнэлгээний 100 хувиар;

11.3.2.5. Хөдөлмөрийн чадвараа алдан цаашид мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхэлж чадахааргүй болсон нь тогтоогдвол тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр;

11.3.3 Даатгагуулагч нас барсан:

11.3.3.1 Даатгуулагч нас барсан тохиолдолд тухайн шүүгчийн нийгмийн даатгалын дэвтрээр баталгаажсан сүүлийн 15 жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр буюу даатгалын үнэлгээний 100 хувиар түүний өв залгамжлагчид нөхөн төлбөрийг олгоно.

11.4. Даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэх:

11.4.1. Даатгагч нөхөн төлбөрийн баримт бичгүүдийг шаардлага хангасан гэж үзвэл ажлын 3-5 хоногийн дотор бүрэн шийдвэрлэнэ.

11.4.2. Даатгагч нөхөн төлбөрийн баримт бичгийг шаардлага хангасан эсэхийг шалгах явцдаа урьдчилгаа болгож 5.000.000 /таван сая/ төгрөгийн нөхөн олговрыг шийдвэрлэнэ.

11.5. Төлбөр нэхэмжлэх эрх шилжүүлэлт/Subrogation

11.5.1. Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.7, Иргэний хуулийн 443.7-д тус тус заасныг үндэслэн даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

11.5.2. Даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн тохиолдолд

Даатгуулагч нь олгогдсон нөхөн төлбөрийг үл маргах журмаар даатгагчид шилжүүлнэ.

11.6. Аливаа том хэмжээний осол, даатгалын тохиолдлын үед:

11.6.1. Даатгалын тохиолдол бүрдсэн үед /аливаа томоохон хэмжээний ослын үед/ талууд зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран хохирлын шалтгаан, хэмжээг тогтоох комисс томилон ажиллуулах ба комиссын бүрэлдэхүүнд даатгалын мэргэжилтэн, инженер-техникийн мэргэжилтэн, даатгуулагч байгууллагын төлөөлөгч байхаас гадна шаардлагатай бол хууль хяналт, гал, ус, цаг уурын албаны төлөөлөгч зэрэг холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

11.6.2. Томилогдсон комисс даатгалын тохиолдлын шалтгаан, хохирлын хэмжээг газар дээр нь шалган шинжлэн судалж, хохирлын шалтгааныг тогтоосон актыг үйлдэнэ.

Арван хоёр. Даатгалд хамрагдахгүй нөхцөл

12.1. Даатгагч Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8,5 дугаар зүйлд заасан үндэслэл үүссэн болон энэхүү даатгалын онцлогоос хамаарч дараах тохиолдлуудад аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд нөхөн төлбөр төлөхөөс татгалзана. Үүнд:

12.1.1. Даатгуулагч эсвэл даатгагдсан этгээд гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхээр завдсан үед учирсан осол гэмтэл;

12.1.2. Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;

12.1.3. Согтууруулах ундаа, мансууруулах бодис болон эм хэтрүүлэн хэрэглэсэн, жолоодох эрхгүй хүнд жолоогоо дур мэдэн шилжүүлсний улмаас даатгалын тохиолдол бүрдсэн;

12.1.4. Мэргэжлийн спортын уралдаан тэмцээн, мөн бүхий л дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсон, уулын спорт, агаарын спорт болон шүхрийн спортод оролцсоны улмаас үүссэн осол гэмтэл;

12.1.5. Ан хийх үед гарсан осол гэмтэл;

12.1.6. Давагдашгүй хүчин зүйл байгалийн гамшиг, газар хөдлөлтийн улмаас гэрээний нөхцөл биелэгдэх боломжгүй болох тохиолдол

12.1.7. Өвчин эмгэг, төрөлт, төрөхийн хүндрэл, ДОХ, бэлгийн замын халдварт өвчин;

12.1.8. Даатгуулахаас өмнө болон даатгалын хугацаа дууссан үед учирсан осол гэмтэл, түүний үр дагавар;

12.1.9. Даатгуулагч нь даатгалд хамрагдахаас өмнө учирсан ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх зорилгоор дахин эмчилгээ хийлгэж эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол

12.1.10. Даатгуулагч гэнэтийн ослын улмаас гэмтэж бэртэн даатгалын нөхөн төлбөр авсаны дараа уг гэмтлийн үр дагаврыг эмчлүүлэхээр дахин нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх, амралт, сувиллын газар эмчлүүлэх сувилуулах зардал;

Арван гурав. Гэрээний нууцлал

13.1. Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон Талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, Ноу-Хауг хугацаагүй чанд нууцалж, бусдад дамжуулах, хэвлэн нийтлэхгүй байх үүрэгтэйгээр хадгална.

Арван дөрөв. Гэрээний хариуцлага

14.1.Хэрэв даатгагч энэхүү гэрээний дагуу нөхөн төлбөрийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд хоног тутамд олгогдох нөхөн төлбөрийн 0.05 хувьтай тэнцүү хэмжээний алдангыг Даатгуулагчид төлнө.

14.2.Гэрээ цуцлахдаа гэрээнд заагдсан үндэслэл бүхий гэрээ цуцлах тухай мэдэгдлийг бичгээр 7 хоногийн өмнө нөгөө талдаа өгнө.

14.3.Даатгалын гэрээг дараах үндэслэлээр цуцална. Үүнд:

14.3.1.Энэхүү гэрээний нууцлалыг задруулснаас гэрээний аль нэг талын ашиг сонирхолд хохирол учирсан буюу учирч болох нөхцөл байдал бүрдсэн;

14.3.2.Даатгагчийн санхүүгийн чадавхи илт буурсан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тодорхойлогдсон.

14.4.Даатгалын гэрээ цуцлагдсанаас үүсэх үр дагавар

14.4.1.Гэрээний аль нэг тал энэхүү гэрээний нууцлалыг задруулсны улмаас гэрээний нөгөө талд хохирол учирсан тохиолдолд учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

14.4.2.Талууд даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд үлдсэн хугацаанд ноогдох хураамжаас тухайн даатгалтай холбогдсон зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно.

14.4.3.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гэрээг хүчин төгөлдөр болгох, гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгах, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах боломжгүй нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх үндэслэл гэж үзнэ.

Арван тав. Бусад зүйл

15.1.Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжид заагдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

15.2. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт, өөрчлөлтийг энэхүү гэрээнд бичгээр оруулсан нөхцөлд уг өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилнэ.

15.3.Маргаан шийдвэрлэх: Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа асуудал, маргааныг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний талуудын эрх тэгш байдлын үндсэн дээр аль болох эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

15.4.Харилцаа холбооны хэлбэр: Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа харилцааг гэрээнд дурьдсан хаягаар хандаж албан ёсоор хүргүүлэх, шуудан, факс эсхүл цахим мэйл ашиглан бичгээр гүйцэтгэнэ. Ингэхдээ мэдээлэл хүргүүлж буй талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсан байна.

15.5.Энэхүү гэрээг ___ хуудас бүхий 2 хувь үйлдсэн бөгөөд гэрээний эх хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДААТГУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Имейл хаяг:

Утас:

Хаяг:

Имейл хаяг:

Утас:

Хаяг: